42. Чүлтэмийн Загдхорлоо - Гэрийн ажилтай
43. Бавуугийн Нэргүй - Хэрлэн өртөөний замчин
44. Маньбазарын Ням - Гэрийн ажилтай
45. Мягмарын Цэрэнцогзол - Гэрийн ажилтай
46. Долгорын Энхжаргал - Гэрийн ажилтай
- Чулуунхороот сум**
47. Цэнд-Аюушийн Адъяа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 5 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Дундговь аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай

Олон хүүхэд төрүүлж, өсгөн дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор хүмүүжүүлсэн Дундговь аймгийн харьяат дор шагнасугай.

"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:

Өлзийт сум

1. Нацагийн Зансранорол - 5 дугаар багт малчин
2. Авирмэдийн Мядаг - 9 дүгээр багт малчин

Сайнцагаан сум

3. Мишигийн Нарангэрэл - 3 дугаар багт малчин
4. Думаасүрэнгийн Оюунчимэг - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг

"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:

Адаацаг сум

1. Халтарын Наранцэцэг - 3 дугаар багт малчин
2. Мягмарын Ундраа - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг

Гурвансайхан сум

3. Шаравын Болорчулуун - Чулуут багт малчин

Дэлгэрхангай сум

4. Марусягийн Мөнхтуяа - 1 дүгээр багт малчин

Дэлгэрцогт сум

5. Цэвээндоржийн Долгормаа - 3 дугаар багт малчин
6. Оргодолын Отгонтуяа - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг

Дэрэн сум

7. Нямсүрэнгийн Оюунбадам - 1 дүгээр багт малчин

Өлзийт сум

8. Чулууны Хэнбиш - 2 дугаар багт малчин

Өндөршил сум

9. Батсүхийн Бат-Энх - 1 дүгээр багт малчин
10. Бандийн Энхжаргал - 2 дугаар багт малчин

Луус сум

11. Борын Оюунчимэг - Наран багт малчин
12. Санжидмаагийн Цэрэннадмид-Хүүхдийн цэцэрлэгт туслах багш

Сайнцагаан сум

13. Шагдарын Оюунчимэг - 6 дугаар багт малчин

14. Бямбаагийн Тунгалаг - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг

15. Гүндийн Ундармаа - 3 дугаар цэцэрлэгт туслах багш

16. Давдайн Эрдэнэчулуун - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг

Сайхан-Овоо сум

17. Бужигрын Цогдэлгэр - 4 дүгээр багт малчин

Хулд сум

18. Бямбаагийн Алгирмаа - Бүлээн багт малчин
 19. Туваанжамцын Цэмбэлмаа - Уул багт малчин

Цагаандэлгэр сум

20. Батсуурийн Мөнхдэлгэр - Хүний эмнэлэгт асрагч

Эрдэнэдалай сум

21. Хоролын Баасансүрэн - 4 дүгээр багт малчин

22. Лувсандагвын Доржханд - Өндөр насны тэтгэвэрт
 23. Цэгмидийн Эрдэнэцэцэг - Хувиараа хөдөлмөр эрхэлдэг

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 5 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

Завхан аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай

Олон хүүхэд төрүүлж, өсгөн дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор хүмүүжүүлсэн Завхан аймгийн харьяат дор шагнасугай.

"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:

Алдархаан сум

1. Гончигийн Роломсүрэн - Гэрийн ажилтай

Асгат сум

2. Загдын Даваажав - Гэрийн ажилтай

Сантмаргац сум

3. Санжсүрэнгийн Цацрал - Гэрийн ажилтай

Тосонцэнгэл сум

4. Түвдэнгийн Цэнд-Аюуш - Гэрийн ажилтай

"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:

Алдархаан сум

1. Батдоржийн Цэцэгээ - Чигэстэй багийн малчин ажилтай

Баянтэс сум

2. Түмбээгийн Аюушжав - Гэрийн ажилтай

3. Базаррагчаагийн Дайриймаа - Гэрийн ажилтай

4. Хүрлээгийн Дайриймаа - Гэрийн ажилтай

5. Аюушийн Лхагвадулам - Гэрийн ажилтай

6. Чийбаатарын Отгонтөр - Гэрийн ажилтай

7. Цэвэгдоржийн Хандсүрэн - Гэрийн ажилтай

Дорволжин сум

8. Аюушжавын Сарангэрэл - Цогт багийн малчин

9. Ойдовын Эрдэнэцэцэг - Тавантолгой багийн малчин

Завханмандал сум

10. Лааганжавын Уранчимэг - Гэрийн ажилтай

Нөмрөг сум

11. Даваажавын Нарангэрэл - Нуур багийн малчин

Отгон сум

12. Намхайнямбуугийн Долгорсүрэн - Буянт багийн малчин

13. Батмэндийн Оюунцэцэг - Буянт багийн малчин

14. Пүрэвийн Лхамсүрэн - Соёл багийн малчин

15. Цэнд-Аюушийн Цэвэлмаа - Баянбулаг багийн малчин

Сантмаргац сум

16. Гончигийн Цэрэннадмид - Гэрийн ажилтай

Тосонцэнгэл сум

17. Бат-Эрдэнийн Бямбажав - Гэрийн ажилтай

18. Доржготовын Жамъянсүрэн - Г э р и й н ажилтай

19. Дамдингийн Тогтоохаргал - Гэрийн ажилтай

20. Цэрэннамжилын Сольхүү - Гэрийн ажилтай

Түдэвтэй сум

21. Галдандэмбэрэлийн Эзэнхүү - Сумын холбооны техникч

Тэлмэн сум

22. Цэрэндоржийн Анхтуяа - Өгөөмөр багийн малчин

23. Жанчивын Цогтбаяр - Өгөөмөр багийн малчин

24. Нансалмаагийн Цэрэнлхам - Гэрийн ажилтай

Улиастай сум

25. Шунтайн Билэгт - Гэрийн ажилтай

26. Дарьбазарын Жаргал - Цагдаагийн газар үйлчлэгч

27. Намсрайн Наранцэцэг - Гэрийн ажилтай

28. Өлзийхүүгийн Нямсүрэн - Гэрийн ажилтай

29. Бэгзийн Өлзий - Гэрийн ажилтай

30. Гүнрэгжавын Халтар - Гэрийн ажилтай

31. Ламжавын Ханд - Гэрийн ажилтай

32. Пүрэвийн Цэцэгээ - Гэрийн ажилтай

33. Жамсрандоржийн Цэнджав - Нэгдсэн эмнэлгийн тогооч

34. Борын Чимэд - Гэрийн ажилтай

35. Мангаагийн Чулуунцэцэг - Гэрийн ажилтай 36. Сандагийн Янжинсүрэн - ХААН банкинд теллер	37. Жамсранжавын Мөнхбат - Баянбулаг багийн малчин
Цагаанхайрхан сум МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ	
2006 оны 5 дугаар сарын 26-ны өдөр	Дугаар 112
Орхон аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай	
Олон хүүхэд төрүүлж, өсгөн дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор хүмүүжүүлсэн Орхон аймгийн харьяат дор шагнасугай.	
"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:	
Баян-Өндөр сум 1. Жамцын Гансүрэн - Гэрийн ажилтай 2. Аюушийн Мягмарсүрэн - Тэтгэвэрт 3. Агваанчүлтэмийн Оюунцэцэг - Гэрийн ажилтай	4. Навааны Цагаанхүү - Гэрийн ажилтай 5. Пилжээгийн Цанхиа - Тэтгэвэрт Жаргалант сум 6. Намдагийн Сампилмаа - Тэтгэвэрт 7. Шарын Дэлгэрцогт - Тэтгэвэрт
"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:	
Баян-Өндөр сум 1. Адыагийн Бадамсамбуу - Малчин 2. Жасрайн Батгэрэл - Групптэй 3. Гэндээгийн Батжаргал - Гэрийн ажилтай 4. Баянмөнхийн Баярмаа - Малчин 5. Юндэндоржийн Баярмаа - Гэрийн ажилтай 6. Харнүдэнгийн Бөхчулуун - Гэрийн ажилтай 7. Дэжээгийн Буяндэлгэр - Гэрийн ажилтай 8. Доржийн Бүрэнтөгс - 5 дугаар цэцэрлэгт туслах багш 9. Лувсандагвын Ганцэцэг - Гэрийн ажилтай 10. Санзайн Ганчимэг - Гэрийн ажилтай 11. Лувсандоржийн Дамдинсүрэн - Тэтгэвэрт 12. Батнасангийн Долгор - Гэрийн ажилтай 13. Чимэдийн Дэнсмаа - Гэрийн ажилтай 14. Ёндонжамцын Мөнхжаргал - Төмөр замд вагон үзэгч 15. Чойжилын Мөнхсүрэн - Гэрийн ажилтай 16. Доржпаламын Мөнхтуяа - Гэрийн ажилтай 17. Хандын Мягмарсүрэн - Гэрийн ажилтай 18. Долгорын Нямсүрэн - Малчин 19. Ринагийн Отгон - ХЭАА эрхэлдэг	20. Хумгалын Отгончимэг - ХЭАА эрхэлдэг 21. Цанжидын Оюунбилэг - Гэрийн ажилтай 22. Чадраабалын Оюунбилэг - Гэрийн ажилтай 23. Цэдэвийн Оюунчимэг - Тэтгэвэрт 24. Доржоогийн Төмөрсүрэн - 5 дугаар цэцэрлэгт туслах багш 25. Чимэддоржийн Тунгалаг - Гэрийн ажилтай 26. Балжидын Ундармаа - Гэрийн ажилтай 27. Очирбатын Өсөхбаяр - Гэрийн ажилтай 28. Бандийн Цэрмаа - Гэрийн ажилтай 29. Лувсансүрэнгийн Цэгмид - Төмөр замын орон сууцанд жижүүр 30. Нямбуугийн Цэрэннадмид - "Эрдэнэт хивс" ХХК-д тооцоологч 31. Чимэдийн Энхтүвшин - Гэрийн ажилтай 32. Бавуудоржийн Эрдэнэчимэг - Гэрийн ажилтай 33. Гэндэнгийн Дуламсүрэн - Тэтгэвэрт Жаргалант сум 34. Чулууны Алтанхуяг - ХЭАА эрхэлдэг 35. Жинсхааны Дарьжав - Гэрийн ажилтай
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
2006 оны 5 дугаар сарын 26-ны өдөр	Дугаар 113
Өвөрхангай аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай	
Олон хүүхэд төрүүлж, өсгөн дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор хүмүүжүүлсэн Өвөрхангай аймгийн харьяат дор шагнасугай.	
"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:	

Баруунбаян-Улаан сум

1. Доржийн Пүрэвтогтох - 1 дүгээр багийн малчин

Баян-Өндөр сум

2. Содномдагвын Зууннаст - Гэрийн ажилтай

Бүрд сум

3. Гомбосүрэнгийн Наранцэцэг - 4 дүгээр багийн малчин

Гучин-Ус сум

4. Гончигдамбын Нарантуяа - 4 дүгээр багийн малчин

Сант сум

5. Дашийн Даваажав - Гэрийн ажилтай

6. Жамсрангийн Лхамсүрэн - 1 дүгээр багийн малчин

Төгрөг сум

7. Цэдэнбалжирын Ханд - 3 дугаар багийн малчин

"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:

Арвайхээр сум

1. Төмөрбатын Бумандулам - Гэрийн ажилтай

2. Доржсүрэнгийн Даваасүрэн - Гэрийн ажилтай

3. Баасангийн Долгорсүрэн - Гэрийн ажилтай

4. Санзайн Нарандэлгэр - Гэрийн ажилтай

5. Сэмидийн Наранхүү - "Арцат трейд" ХХК-ийн ажилчин

6. Мөнхөөгийн Наранцэцэг - Гэрийн ажилтай

7. Сосорбурамын Наранцэцэг - Гэрийн ажилтай

8. Иновын Оюун - Нефть хангамжийн газрын тогооч

9. Шагдарсүрэнгийн Цэндбаяр - Г э р и й н ажилтай

10. Төмөрхуягийн Цэрэндолгор - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

11. Сосорбурамын Чанцалдулам - Гэрийн ажилтай

Баруунбаян-Улаан сум

12. Агваанренчингийн Даваа - 3 дугаар багийн малчин

13. Нацагдоржийн Цэнд-Аюуш - 4 дүгээр багийн малчин

14. Лхагвын Энхсүрэн - 4 дүгээр багийн малчин

Бат-Өлзий сум

15. Ичиноровын Зуун-Өлзий - 1 дүгээр багийн малчин

Баянгол сум

16. Норжмаагийн Саранцэцэг - 1 дүгээр багийн малчин

Баян-Өндөр сум

17. Лодойн Сампилмаа - 1 дүгээр багийн малчин

18. Эмээлсүрэнгийн Эрдэнэчимэг - 2 дугаар багийн малчин

Богд сум

19. Самбууэрэнлэйн Оюунсүрэн - 4 дүгээр багийн малчин

20. Дэгддоогийн Цэрэнбямба - 3 дугаар багийн малчин

Бүрд сум

21. Шуурайн Ичинюров - 5 дугаар багийн малчин

22. Дулмаагийн Хишигсүрэн - Гэрийн ажилтай

Гучин-Ус сум

23. Жанцэнгийн Мөнхтулга - Гэрийн ажилтай

24. Төмөртогтохын Энхчулуун - 2 дугаар багийн малчин

Есөнзүйл сум

25. Буяндэлгэрийн Амарсанаа - Гэрийн ажилтай

26. Самбарын Дэлгэрмаа - 2 дугаар багийн малчин

27. Очирхүрээгийн Дэлгэрмаа - 1 дүгээр багийн малчин

28. Сосорбарамын Пүрэв - 1 дүгээр багийн малчин

Зүүнбаян-Улаан сум

29. Чимиддоржийн Төмөрбаатар - 2 дугаар багийн малчин

Нарийнтээл сум

30. Лхамноргины Даваадолгор - 4 дүгээр багийн малчин

31. Үрхүүгийн Отгонцэцэг - 2 дугаар багийн малчин

32. Намдагийн Өлзийтогтох - 3 дугаар багийн малчин

33. Доржсүрэнгийн Сарантуяа - 3 дугаар багийн малчин

Сант сум

34. Содномын Буянхишиг - 2 дугаар багийн малчин

35. Очирдоогийн Намжилмаа - 3 дугаар багийн малчин

36. Цэрэндашийн Одхүү - Цариг багийн малчин

37. Цэвэгсүрэнгийн Отгонжаргал - 2 дугаар багийн малчин

38. Цэгмидийн Пагамжав - 4 дүгээр багийн малчин

39. Чимэдийн Сугарсүрэн - 5 дугаар багийн малчин

40. Дашдондогийн Цэрэн - 11 жилийн сургуулийн багш

41. Цэрэндашийн Цэрмаа - 3 дугаар багийн малчин

42. Эмээлийн Энхтуяа - Засаг даргын Тамгын газрын нярав

43. Чойжамцын Энхцэцэг - 2 дугаар багийн малчин

Тарагт сум

44. Надмиддоржийн Дангаасүрэн - Хүрэмт багийн малчин

45. Оргийн Олзод - Арвайн тал багийн малчин
 46. Балжирын Уранчимэг - Арвайн тал багийн малчин

Төгрөг сум

47. Лувсандоржийн Цэцэгмаа - 3 дугаар багийн малчин
 48. Цэвэлсүрэнгийн Энхцэцэг - Гэрийн ажилтай

Уянга сум

49. Ринчиндоржийн Бямбадулам - Гэрийн ажилтай
 50. Лодойдамбын Дуламдорж - 8 дугаар багийн малчин
 51. Намжилмаагийн Октябрь - 6 дугаар багийн малчин
 52. Пунцагдашийн Тогтоол - 6 дугаар багийн малчин

Хайрхэндулаан сум

53. Лодойдамбын Шийлэгмаа - 1 дүгээр багийн малчин

54. Цэрэндуламын Шийлэгцэрэн - 6 дугаар багийн малчин
 55. Жамбаагийн Энхцэцэг - Цэцэрлэгийн багш

Хархорин сум

56. Жанчивын Алимаа - Гэрийн ажилтай
 57. Лувсандамчаагийн Ариунаа - Гэрийн ажилтай
 58. Дашзэвгийн Наранцрэг - Гэрийн ажилтай

Хужирт сум

59. Жамсрангийн Адъяа - 5 дугаар багийн малчин
 60. Балдандоржийн Бямбадулам - 1 дүгээр багийн малчин
 61. Лувсандоржийн Долгормаа - 1 дүгээр багийн малчин

**МОНГОЛ УЛСЫН
 ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм"-ийг хэвсрэлт ёсоор баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Иргэний хамгаалалтын улсын хяналтын дүрэм"

батлах тухай" Засгийн газрын 1996 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 27 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
 ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД У.ХҮРЭЛСҮХ

Засгийн газрын 2006 оны 105 дугаар тогтоолын хэвсрэлт

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Гамшгаас хамгаалах улсын хяналтын зорилго нь гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, холбогдох стандарт, техникийн норматив, дүрэм, журам, заавар, дэглэмийн биелэлтийг хангуулахад оршино.
- 1.2. Гамшгаас хамгаалах улсын хяналтыг улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ хэрэгжүүлнэ.
- 1.3. Улсын ерөнхий байцаагчийн эрхийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг улсын ерөнхий байцаагч тус тус олгоно.
- 1.4. Улсын байцаагчийн эрх олгох журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд батална.
- 1.5. Улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Гамшгаас хамгаалах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай

хуулиуд болон энэ дүрэм, холбогдох бусад заавар, журмыг мөрдлөг болгоно.

1.6. Улсын байцаагч нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн онцгой байдлын газар, хэлтэст ажиллах бөгөөд улсын байцаагч нь ахлах байцаагчид, ахлах байцаагч нь ерөнхий байцаагчид ажлаа хариуцан тайлагнана.

1.7. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын байцаагчийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

1.8. Улсын байцаагч нь онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдаас загварыг нь баталсан үнэмлэх, тэмдэг, албан шаардлага, мэдэгдэл, танилцуулга, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.9. Гал түймрийн улсын хяналтын байцаагч нь Засгийн газрын 1999 оны 209 дүгээр тогтоолоор батлагдсан "Гал түймрийн улсын хяналтын дүрэм"-ийг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр, Гамшгаас хамгаалах улсын хяналт явуулах чиглэл

Гамшгаас хамгаалах улсын хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

2.1. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт;
2.2. Гамшгаас хамгаалах шаардлагыг тодорхойлсон стандарт, норм, техникийн норматив, дүрэм, заавар, журам, дэглэмийн биелэлт;

2.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын гамшгаас хамгаалах арга хэмжээний төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт;

2.4. Гамшгаас хамгаалах алба, штаб, аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал;

2.5. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг харилцаа холбоо, мэдээллийн байгууллага өмчийн төрөл хэлбэрээс үл хамааран үнэ төлбөргүй, саадгүй дамжуулах бэлтгэл;

2.6. Улсын болон гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэлт, нөхөн сэлбэлт, хадгалалт, хамгаалалтын чанар, байдал;

2.7. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны ажлын зохион байгуулалт, хамралт, чанар, үр дүн;

2.8. Аврах ажиллагаа явуулахад дайчлах хүч хэрэгсэл болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг татан оролцуулах ажлын бэлтгэл, хэрэгжилт;

2.9. Аюулт үзэгдлийг мэдээлэх, цацраг идэвхт болон химийн хорт бодисыг хянах, хэмжих автомат тоног төхөөрөмж, аврах ажлын техник, багаж хэрэгслийн нөхөн хангалт, ашиглалт, хадгалалтын байдал.

Гурав, Гамшгаас хамгаалах улсын

хяналтын байцаагчийн эрх, үүрэг

3.1. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхээс гадна дор дурдсан эрх эдэлнэ:

3.1.1. гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын нөхцөл шалтгаан, гэм буруутай этгээдийг тогтоох зорилгоор албан тушаалтан, иргэдээс тайлбар, тодорхойлолт гаргуулан авах;

3.1.2. гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед мэдээллийн болон тээврийн хэрэгслийг өмчийн хэлбэр, дараалал харгалзахгүй /нөхөн төлбөртэй/-гээр ашиглах.

3.2. Улсын байцаагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

3.2.1. гамшгаас хамгаалах улсын хяналтыг энэ дүрмийн 2 дугаар зүйлд заасан чиглэлийг баримтлан хэрэгжүүлэх;

3.2.2. илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авах явцад аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, хөндлөнгийн нөлөөнд үл автан, албан үүргээ үнэнчээр гүйцэтгэх;

3.2.3. хяналт шалгалт хийж гаргасан дүгнэлт, акт, үйлдсэн нотломж, албан шаардлага, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах.

Дөрөв, Бусад зүйл

4.1. Улсын байцаагчийн хууль ёсны шийдвэрийг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

4.2. Зөрчил гаргасан этгээд түүнд ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийг тогтоосон хугацаанд улсын төсвийн орлогод оруулна.

4.3. Улсын байцаагчийн гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл аж ахуйн нэгж, байгууллага, иргэн улсын ахлах болон ерөнхий байцаагчид гомдол гаргана. Улсын ахлах болон ерөнхий байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

4.4. Улсын байцаагч нь үүргээ биелүүлээгүй болон хууль зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан, Ж.Болдбаатар, Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн

даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд эгзэлтэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч иргэн А.Эрдэнэцогт, Улсын Их Хурлын даргын 2006 оны 4 дүгээр сарын

26-ны өдрийн 66 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог нар оролцов.

Улсын Их Хурлын даргын 2006 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 60 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Ерөнхий сайдын зөвлөх Б.Долгор, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ж.Сүхбаатар нарыг өргөдөл гаргагч татгалзах тухай хүсэлт гаргасныг Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүн хэлэлцэж, аман магадлалаар дээрх хүмүүсийг Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд Улсын Их Хурлыг төлөөлүүлэн оролцуулах боломжгүй гэж үзлээ.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн оршин суугч, иргэн А.Эрдэнэцогт Үндсэн хуулийн цэцэд хандаж 2006 оны 3 дугаар сарын 10-ний өдөр гаргасан мэдээлэлдээ:

"1. 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн заалтын дагуу холбогдох сонгуулийн хороодын гаргасан шийдвэр нь Улсын Их Хурлын сонгуультай холбогдсон зарим маргааны хувьд эцсийн шатны шийдвэр байх агуулгаар зохицуулагдсан нь, мөн уг хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсгийн заалтаар иргэний сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд органик хуулиар тавигдаж буй нийтлэг шаардлага болон захиргааны журамтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гаргасан шийдвэрийн талаарх маргааныг Үндсэн хуулийн цэцэд харьяалуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй" гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн дээрх заалт нь иргэн, хуулийн этгээд, өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл зөрчилдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд хандах үндсэн эрхийг ямарваа нэгэн хэлбэрээр, тэр дундаа Үндсэн хуулийн бус үндэслэлээр хууль гаргаж хязгаарлах, хасахыг хориглосон Үндсэн хуулийн баталгаа мөн.

Гэтэл Улсын Их Хурлын сонгуулийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн заалтаар, тухайлбал иргэний сонгох эрхтэй холбогдсон гомдол нь холбогдох сонгуулийн хороонд гомдлоо гаргаснаар хязгаарлагдаж байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасны дагуу шүүхэд хандах эрхээ хэсүүлахэд хүргэж байна.

Мөн энэхүү заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийн Монгол Улсын иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох

эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн. Учир нь Улсын Их Хурлын сонгуулийн шинэчилсэн хуулийн 57 дугаар зүйлийн "Сонгуулийн хууль тогтоож зөрчсөн маргааныг шийдвэрлэх харьяалал" гэсэн малгай гарчгийн дор багтаж буй 57.1 дэх хэсгийн заалтад иргэний сонгох эрхтэй холбогдсон гомдлыг холбогдох сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэх хүрээнд хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан иргэний сонгох эрхийг зарим талаар хязгаарлахад хүрч байна.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтаар Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д заасан эрх нь сонгуулийн хороодын шийдвэрээр зөрчигдсөн гэж үзвэл Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасны дагуу шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг нь хассан байна.

2. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтаар Үндсэн хуулийн заалт зөрчигдсөн тухай маргаан бус харин органик хуулийн нэн тодорхой заалт зөрчигдсөн тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд харьяалуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1-д "Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" хэмээн заасан. Үүнтэй холбогдуулан Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих гэдэгт юуг хамааруулж ойлгох талаар зайлшгүй хөндөх шаардлага гарч байна. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих гэдэгт юуны өмнө уг маргаан нь Үндсэн хуульд өөрт нь заасан ёсоор хууль зүйн хамгийн дээд хүчин чадалтай акт болох Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн тухай маргаан байх, маргааны хэмжүүр нь гагцхүү Үндсэн хууль өөрөө байх, түүнчлэн маргааны зүйл нь төрийн хамгийн дээд байгууллага, түүний өндөр зиндааны албан тушаалтны үйл ажиллагаа байх гэсэн үзүүлэлтүүд хамаарна. Энэ шалгуурт тэнцэж байвал Үндсэн хуулийн биелэлтэд тавьж буй дээд хяналт болно гэж үзэж байна. Гэтэл Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтаар Үндсэн хуулийн цэцийн маргааны хэмжүүр нь Үндсэн хуулийн зүйл, заалт бус, зөвхөн органик хуулийн маш тодорхой зүйл, заалтаар хэмжүүр хийж зайлшгүй шаардлагыг Цэцэд тулгасан байна. Учир нь маргааныг хянан шийдвэрлэхэд баримтлах шаардлага, шалгуур, журам нь Үндсэн хуульд бус харин органик хуульд өөрт нь маш дэлгэрэнгүй агуулагдаж байгаад оршино. Энэ нь ч зүйн хэрэг. Тэдгээр нь ердийн хуульд байвал зохих нийтлэг шаардлага, журам учраас түүнтэй холбогдсон маргаан нь үнэн хэрэгтээ Үндсэн хуулийн бус маргаан юм. Ийм

шинж бүхий маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх нь Үндсэн хуулийн дээд хяналтын ач холбогдлыг бууруулахад хүргэх бөгөөд ингэснээр Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих... байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болох шинжээ алдахад хүрнэ.

Ийн болон бусад үндэслэлээр Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь заалт Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн байна. Үүн дээр нэмж Цэцийн өөрийнх нь үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй" хэмээн тов тодорхой заасныг Цэцийн жишиг хэмээн үзэж иш татан нотолгоо болгож байна.

3. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь заалтаар Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан шийдвэрийн талаарх маргааныг бүхэлд нь Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байхаар харьяалуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг болон мөн зүйлийн 2 дахь хэсгийн эхний заалтыг тус тус зөрчсөн. Учир нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т буй "ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх"-ийг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргах үндэслэл нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн эхний заалтын дагуу Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан байх явдал юм.

Энэ шаардлага нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн "Үндсэн хуулийн биелэлтэд тавих дээд хяналт" гэсэн 8 дугаар зүйл болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн "Маргааны харьяалал" гэсэн 13 дугаар зүйлд тус тус Үндсэн хуульд заасны дагуу зохих ёсоор хуульчлан баталгаажсан байна. Гэтэл Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь заалтад Үндсэн хуулиар үг, үсэгчлэн хэлж, зориуд тогтоосон Үндсэн хуулийн цэцэд харьяалагдах маргааны гол шалгуур болох "Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан" гэдэг шаардлагыг органик хуулийн энэ заалтад гээж орхижүүлжээ. Үүний улмаас Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг Сонгуулийн ерөнхий хороо зөрчсөн тухай өргөдлийг Үндсэн хуулийн цэц хүлээн авахаас өөр замгүй болгож байгаа нь энэ заалтын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл мөн гэж үзэж байна. Ингэснээр Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуулийн бус маргааныг шилжүүлж байгаа хэрэг болох бөгөөд үүний улмаас Үндсэн хуулийн дээрх зүйл, заалтууд давхар зөрчигдөж байна.

Дээрх үндэслэлүүдийг анхааран үзэж Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалт болон мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9; Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн эхний догол мөрийн заалтад тус тус нийцээгүй болохыг магадлан шийдвэрлэж өгөхийг хүсье" гэжээ.

Иргэн А.Эрдэнэцогт 2006 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдлийн шаардлагын үндэслэлийг ихэсгэх тухай мэдээллэдээ:

1. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т буй "ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсний, "шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчсөн. Үндсэн хуулийн эл заалт хууль тогтоох эрх мэдлийн үйл ажиллагаанд ч нэгэн адил баримтлагдах учиртай Үндсэн хуулийн суурь зарчим мөн.

Хууль дээдлэх зарчим нь парламентаас баталсан хуулийг нийтээр дагаж мөрдөх болон хууль нэг мөр хэрэгжих ёстой гэх ойлголтоос илүү өргөн хүрээтэй буюу хууль нь бодит зүй тогтолд тулгуурласан, түгээмэл шинжийг агуулж байх, хууль хүлээн зөвшөөрөгдөхүйц, итгэл үнэмшил төрүүлэхүйц байх ёстой гэдэг гүн гүнзгий утга агуулгыг шингээсэн ойлголт болно. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь заалт нь хуулийн бодит зүй тогтолд тулгуурлаагүй, түүний түгээмэл шинжийг алдагдуулсан байх бөгөөд томъёолол нь хууль тогтоогчийн дур зоргын илрэл байх шинжийг агуулж байгаагаараа хуулийн бодит чанарыг олоогүй байна. Үүнд тухайлбал, уг хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь заалтуудаар Улсын Их Хурлын сонгуультай холбоотой эрх зүйл зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх журам хэргийн харьяаллыг буюу аль шүүх хянан шийдвэрлэхийг шууд нэг бүрчлэн заан тогтоосон нь хуулийн бодит чанарыг алдагдуулж, түүний түгээмэл зүй тогтлыг зөрчсөн байна. Хэрэг, маргааны харьяаллыг тухайн процессийн гол хуульд нь зааж, үүнтэй холбогдон үүссэн шүүх хоорондын маргааныг дээд шатных нь шүүх түүнчлэн Үндсэн хуулийн цэц зохих хууль, журмын дагуу шийдвэрлэдэг нь хуулийн бодит чанар мөн бөгөөд дэлхий нийтэд тогтсон түгээмэл зүй тогтол болно. Гэтэл хууль тогтоогч үүнийг анхаараагүй нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн гэдэг дүгнэлтэд хүргэж байна. Үүнийг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь заалтад ч нэгэн адил хамааруулж байна.

Дээрх үндэслэлийг анхааран үзэж Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн хоёрдахь заалтад тус тус нийцээгүй болохыг магадлан шийдвэрлэж өгөхийг хүсье" гэжээ.

Хоёр. Улсын Их Хурлын даргын 2006 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 66 дугаар захирамжаар Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Д.Дондоо Үндсэн хуулийн цэцэд хандаж 2006 оны 5 дугаар сарын 17-ны өдөр гаргасан тайлбартаа:

1. Олон улсын Хүний эрхийн Пакт, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д заасан иргэний улс төрийн гол эрх буюу "сонгох, сонгогдох" эрхийн баталгааг хангах, иргэнээс энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, түүнийг гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар зохицуулдаг билээ. Өөрөөр хэлбэл, сонгуулийг зохион байгуулж явуулдаг байгууллагын гол үүрэг бол Үндсэн хуулиар заасан иргэний улс төрийн эрхийн баталгааг бүрэн ханган биелүүлэх явдал юм. Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн хороодыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар ханган ажиллахдаа захирах, захирагдах зарчим буюу доод шатны байгууллага нь дээд шатны байгууллагадаа шатлан захирагдах төрийн захиргааны эрх зүйн ерөнхий зарчмыг иш үндэс болгодог тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10-т "Хуульд өөрөөр заагаагүй бол хэсгийн болон салбар хорооны шийдвэрийн талаар тойргийн хороонд, тойргийн хорооны шийдвэрийн талаар Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны хороо гомдлыг хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ", 57.1-д сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргаж байхаар хуульчилсан.

Сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан асуудалтай холбогдсон гомдолтой холбогдуулан зохих шатны сонгуулийн хорооноос гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Үндсэн хуульд заасан эрхийнхээ дагуу иргэн шүүхэд хандах эрх нь эрхлэлтэй байгаа болно. Өөрөөр хэлбэл, хуулийн 57.1 дэх заалтаар шүүхэд гомдол гаргах иргэний эрхийг ямар нэг байдлаар хязгаарлаагүй, зөвхөн доод шатны сонгуулийн хорооны шийдвэрийг дээд шатны сонгуулийн хороо хянан шийдвэрлэх харьяаллыг тогтоож өгсөн юм.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т "ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн

төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх"-тэй холбогдсон маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.5-д Монгол Улсын Үндсэн хуульд заасан "сонгуулийн төв байгууллагын шийдвэр" гэдэгт юуг хамааруулахыг нарийвчлан зохицуулсан юм.

Сонгуулийн ерөнхий хороо бол Улсын Их Хурлаас байгуулагдаж, сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулж явуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан бүх шатны сонгуулийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах, Улсын Их Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн бүртгэлийг хүчингүй болгох, тойргийн хорооны шийдвэрийг давж заалдсан гомдол, сонгуулийн асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг харъяаллын дагуу хянан шийдвэрлэх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлж, Үндсэн хуульд заасан иргэний сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргадаг байгууллага билээ.

Түүнчлэн Сонгуулийн ерөнхий хорооны талаар заасан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчсөн тухай дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцээс 2005 онд гаргасныг анхаарч үзсэн. Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зохицуулалтыг хийсэн болно. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.1, 57.5 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна" гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Аливаа парламентын сонгууль улс даяар нэгэн зэрэг эхэлж товлосон цагт дуусгавар болдог нийтлэг зүй тогтолтой. Энэ нь сонгуулийг улс даяар нэгэн зэрэг саадгүй явуулах үндэс болдог хэмээн үздэг. Иймд сонгуулийн холбогдолтой аливаа маргааныг сонгууль явуулж дуустал шүүх болон хөндлөнгийн ямар нэг өөр байгууллага авч хэлэлцдэггүй журамтай байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуулийн дагуу Сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил үүссэн бол сонгуулийн төв байгууллагын шийдвэр гартал сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргааныг шүүх, эсхүл хөндлөнгийн өөр нэг байгууллага авч хэлэлцэхгүй байх нь дээрх ерөнхий үзэл баримтлалд нийцэх юм.

Монгол Улсын Дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн 2006 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн З/83 тоот албан бичигт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 156 дугаар зүйлийн 156.1.1-д заасан "...аж ахуйн нэгж,

байгууллага, тэдгээрийн албан тушаалтнаас гэсний "байгууллага" гэдэгт Сонгуулийн Ерөнхий хороог хамааруулахгүй байх үндэслэлгүй юм. Сонгуулийн ерөнхий хороонд холбогдох, Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн талаар гаргасан иргэдийн гомдлыг ерөнхий харъяаллын дагуу шүүх хянан шийдвэрлэх боломжтой гэж үзнэ" гэжээ. Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д байгаа, сонгуулийн хороод харъяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гарган, улмаар Сонгуулийн ерөнхий хорооноос гарсан Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн шийдвэрийг шүүхийн журмаар хянуулах боломж нээлттэй байх тул Мочгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал харъяаллын дагуу шийдвэрлэхээр уг хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.5 дахь хэсэгт заасан нь өнөөгийн практикт шүүхийн харъяаллын давхардлыг үүсгэхээс сэргийлсэн заалт байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Хөрөнгийг улсын орлого болгох тухай шийдвэрийг Сонгуулийн төв байгууллага шууд гаргаж байгаа нь бусдын өмчлөх эрхэнд шүүхийн бүс замаар халдсан шинжийг агуулжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон **ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.5 дахь заалтууд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Жаран зургадугаар зүйлийн 1, 2 дахь заалтыг зөрчөөгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3 дахь

заалтууд Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсгийн "Энэ хуулийн 41.9, 42.8-д заасан хөрөнгийг улсын орлого болгох шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргах ба энэ талаар гомдол гарвал сум буюу сум дундын, дүүргийн шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчсөн байна.

4. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.6 дахь заалтын үйлчлэлийг 2006 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

5. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮД

Н.ЖАНЦАН

Ж.БОЛДБААТАР

Ж.АМАРСАНАА

Ц.САРАНТУЯА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14803

☎ 329487
Хэвлэлийн хуудас 3